



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ  
БОЛОВСРОЛЫН ГАЗАР

Багшийн хөгжлийн ордон, Энхтайваны өргөн чөлөө 10а,  
11 дүгээр хороолол, 8 дугаар хороо,  
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14191  
Утас/Факс: (976) 7011-3033  
<http://www.edub.edu.mn>

2019.02.02 № 02/154  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ДҮҮРГИЙН БОЛОВСРОЛЫН  
ХЭЛТСИЙН ДАРГА НАРТ

Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын сайдын 2019 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн А/42 тоот тушаалаар батлагдсан “Шалгалт зохион байгуулах тухай” тушаалыг өмчийн бүх хэлбэрийн ерөнхий боловсролын сургуулийн захирлуудад хүргэж хэрэгжилтэд хяналт тавьж, ажиллана уу.

Хавсралт 1 хуудас

ДАРГА



Ж.ГАНТУЛГА

1150500163



МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ,  
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН  
САЙДЫН ТУШААЛ

2019 оны 01 сарын 30 өдөр

Дугаар А/42


Улаанбаатар хот

Шалгалт зохион байгуулах тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2018 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн 46 дугаар зарлиг, Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн 37 дугаар тогтоолын 1.2 дахь заалт, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2013 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн А/79 дүгээр тушаалаар батлагдсан "Оюутан элсүүлэх журам"-ын 2.7 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Их, дээд сургуульд элсэгчдээс заавал авах монгол хэл бичгийн шалгалтын босго оноог 400 байхаар тогтоосугай.
2. Их, дээд сургуульд элсэгчдээс авах монгол хэл бичгийн хичээлийн шалгалтыг 2019 оны 03 дугаар сарын 23-ны өдөр, энэ тушаалын 1-д заасан босго онооны болзол хангаагүй шалгуулагчдаас авах дахин шалгалтыг 2019 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр тус тус зохион байгуулсугай.
3. Энэхүү тушаалын дагуу шалгалтыг зохион байгуулахад шаардагдах хөрөнгийг батлагдсан төсвийн дагуу холбогдох зардлаас гаргахыг Санхүү, хөрөнгө оруулалтын газар /Х.Галсанхүү/-т, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Боловсролын үнэлгээний төв /Ж.Ган-Эрдэнэ/-д тус тус үүрэг болгосугай

САЙД



Д.ЛОГЗОЛМАА

0900144